



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МӨНДИЙН ЯАМ

14210 Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2. Засгийн газрын VII байр.
Утас: 26-36-95. Факс: (976-11) 32-36-41 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn http://www.mohs.mn

ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН САЙД
Б ЭНХ-АМГАЛАН ТАНАА

2020.02.07 № 1а/618
танай -ны № -1

Зөвлөмж хүргүүлэх тухай

БНХАУ-ын Ухань хотод дэгдсэн Коронавирусийн ("2019-nCoV") халдварт дэлхийн олон оронд бүртгэгдэж, ДЭМБ-аас "Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал" ўссэнийг зарлан сээрэмжлүүлээд байгаа билээ.

Коронавирусийн халдварт, уушгины хатгалгаа өвчин нь хурдацтай тархаж байгаа бөгөөд манай орны хувьд уг халдвартын тохиолдол бүртгэгдээгүй байгаа хэдий ч Хятад улстай хил залгаа орны хувьд халвар орж ирэх эрсдэлтэй байна.

Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 08 дугаар тушаалаар батлагдсан "Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам"-ын дагуу мэргэжлийн байгууллагууд эрсдлийн түргэвчилсэн үнэлгээг 3 удаа хийж, эрсдлийн түвшинг "Өндөр" гэж тогтоосон байна.


Иймд танай яам харьяалах байгууллага, нэгжүүдийн ажилтан, үйлчлүүлэгчдийг тус вирусийн халдварт өртөхөөс сэргийлэх, эрүүл, аюулгүй ажиллах, үйлчлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлж дараах зөвлөмжийг үйл ажиллагаандaa хэрэгжүүлж ажиллана уу.

1. Вирусын халдвараас сэргийлэх зөвлөмж, анхааруулгыг ЭМЯ-ны вэб хуудас (<http://www.mohs.mn/news/4214>) болон фейсбүүк цахим хуудас (<http://www.facebook.com/www.mohs.mn>)-с авч, мэдээллийг цаг алдалгүй хүргэх арга хэмжээг зохион байгуулах;
2. Улсын бүртгэлд бүртгэгдсэн хлор агуулсан халдвартгүйжүүлэх бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу зөв найруулж, үйлчлэх хугацааг баримтлан, арчих болон шүрших аргаар халдвартгүйжүүлэлт хийх;
3. Хилээр байнга нэвтэрч байгаа том оврын болон бусад тээврийн хэрэгслийн жолооч нар гараа савандаж угаах, БНХАУ-ын хил нэвтэрсэн тохиолдолд машинаас буухгүй байх, бээлий, шүүлтүүртэй амны хаалтыг хэрэглэх, гар халдвартгүйжүүлэх уусмалыг байнга авч явах, хүнтэй гар барихгүй байх, хэрэглэсэн бээлий, гар нүүрний алчуур зэргийг байнга угааж, халдвартгүйжүүлж байх;

• 144201335

4. Машины кабины дотор тал, жолооны хүрд, хаалганы бариул, толь, утас зэргийг 2 цаг тутам цэвэрлэж, халдвартгуйжүүлэх;
5. Онгоц, галт тэрэг, нийтийн тээврийн хэрэгслийг үйлчилгээ эхлэхийн өмнө, завсарлах, ажил дууссаны дараа халдвартгуйжүүлэх бодисоор шүршиж халдвартгуйжүүлэх;
6. Ажлын байр, өрөө тасалгаанд чийгтэй цэвэрлэгээг өдөрт 2-оос доошгүй удаа хийж, олон хүний гар хүрч, амархан бохирдох эрсдэлтэй хаалганы бариул, код, утас, компьютер, дэлгэц, унтраагуур, цахилгаан шатны товчлуур, шатны бариул, ширээ, ариун цэврийн өрөө зэргийн цэвэрлэгээ, халдвартгуйжүүлэлтийг 2 цаг тутам, болон бохирлогдсон тохиолдол бүрт хийх;
7. Олон нийттэй харилцдаг ажилтан, албан хаагчдыг гар угаах нөхцлийг бүрдүүлж, нэг удаагийн амны хаалт хэрэглүүлэх;
8. Цэвэрлэгээ, үйлчилгээний ажилтнууд хөдөлмөр хамгааллын хувцсыг өмсөж, цэвэрлэгээний материал хэрэгслийг хэрэглэсний дараа угааж, халдвартгуйжүүлэх;
9. Хог цуглуулах цэг, хогийн савыг шаардлагатай газруудад байрлуулж, дүүргэлгүй сулаж, цэвэрлэж халдвартгуйжүүлж байх.

Хавсралт 6 хуудастай.



1. Гипохлорид натри (белизна)

Үйлчлэгч бодис: Хлорын хүчлийн давс (NaOCl)

Хэрэглэх заавар:

- Гипохлорид натри нь нянгийн эсрэг үйлчилгээтэй. Голомтын болон урьдчилан сэргийлэх халдвартгуйжүүлэлтэд өргөн хэрэглэдэг.
- Халдвартгуйжүүлэлтэд 0,25%-1% идэвхит хлор агуулсан ажлын уусмалыг ашиглана.
- Уусмалын идэвхээ амархан алддаг тул хэрэглэх бүрдээ шинээр бэлтгэж, 24 цагийн дотор хэрэглэж дуусгана.
- Зөвлөн эдлэл, хөтөвч, цэвэрлэгзэний материал(шал, тоосны алчуур гэх мэт)-ыг 1кг-д 4-5л уусмал зарцуулна.
- Нийтийн талбай, өрөө тасалгааны шал, хана, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг 0,25% ажлын уусмал бэлтгэж ашиглана.
- Ариун цэврийн өрөөг 1% ажлын уусмалаар халдвартгуйжүүлнэ.
- Металл сав суулгыг гэмтээх, зэврүүлэх, даавуун материалыг гэмтээх цайруулах нэлвэйтэй тул болгоомжтой хэрэглэх.

Халдвартгуйжүүлэх уусмал бэлтгэх арга:

Белизна дахь идэвхтэй хлорын хэмжээ, %	10 литр ажлын уусмал бэлтгэх 0,25%-ийн уусмал бэлтгэх (мл)*	10 литр ажлын уусмал бэлтгэх 1%-ийн уусмал бэлтгэх (мл)**
17	150	600
12	210	840

Жишээ нь:

*10 литр 0,25 %-ийн ажлын уусмал бэлтгэхдээ 9 л 850 мл усан дээр 150 мл белизна нэмнэ.

**10 литр 1 %-ийн ажлын уусмал бэлтгэхдээ 9 л 400 мл усан дээр 600 мл белизна нэмнэ.

2. ДП-2Т

Үндсэн үйлчлэгч бодис: трихлоризоциануровын хүчил

Хэрэглэх заавар:

- Эрүүл мэндийн байгууллага, хүүхэд, хүнс, нийтийн үйлчилгээний газарт орчны гадаргуугийн халдвартгуйжүүлэлтэд өргөн хэрэглэдэг.
- Грамм сөрөг, грамм зэрэг бактер (сүрьеэгийн савханцар), вирус, Кандида, Трихофитон төрлийн мөөгөнцөрийн эсрэг үйлчилгээтэй.
- Бэлтгэсэн ажлын уусмалаар арчих, шүрших, дүрэх зэрэг аргуудаар халдвартгуйжүүлэлт хийнэ. 1м² талбайд зарцуулах норм 150мл.
- Идэвхитэй хлор нь 100гр бодист 32%-аас багагүй
- Бэлтгэсэн ажлын уусмалын хүчинтэй хугацаа 24 цаг.
- Нийтийн талбай, өрөө тасалгааны шал, хана, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг 0,01-0,02 % ажлын уусмал бэлтгэж ашиглана.
- Ариун цэврийн өрөөг 0,03% ажлын уусмалаар халдвартгуйжүүлнэ.

Халдвартгуйжүүлэх уусмал бэлтгэх арга:

Ажлын уусмал бэлтгэх хувь хэмжээ %	Шахмалын тоо (1 шахмал=5 гр)	
	10 литр усанд	20 литр усанд
0.01*	-	1
0.02**	1	2
0.03***	-	3

Жишээ нь:

*20 литр, 0,01 %-ийн ажлын уусмал бэлтгэхдээ 20 литр усанд 1 шахмал ДП-2П хийнэ.

**10 литр, 0,02 %-ийн ажлын уусмал бэлтгэхдээ 10 литр усанд 1 шахмал ДП-2П хийнэ.

***20 литр, 0,03 %-ийн ажлын уусмал бэлтгэхдээ 20 литр усанд 3 шахмал ДП-2П хийнэ.

3. Жавелион (*Javelion*)

Үндсэн үйлчлэгч бодис: Натрий дихлор изоциануровой хүчил

Хэрэглэх заавар:

- Хүүхдийн байгууллага, хүнсний үйлдвэрлэл үйлчилгээний газар, тээврийн хэрэгсэл, ахуйн үйлчилгээний газрууд, соёл амралт, спортын байгууллагуудад хэрэглэнэ.
- Найруулсан ажлын уусмалыг 3 хоног хадгална.
- Жавелионыг шилэн паалантай, пластмассан саванд бэлтгэнэ.
- Гадаргуу халдвартгүйжүүлэхэд 1м²-д 100мл -150мл бодис орохоор бодож арчих юмуу шүршинэ
- Цагаан хэрэглэлд 1кг-д 4л бодис орно.
- Нийтийн талбай, өрөө тасалгааны шал, хана, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг 0,015-0,03 % ажлын уусмал бэлтгэж ашиглана.
- Ариун цэврийн өрөөг 0.03-0,06 % ажлын уусмалаар халдвартгүйжүүлнэ.

Халдвартгүйжүүлэх уусмал бэлтгэх арга:

Агуулагдаж байгаа идэвхтэй хлорын хувь	10 л усанд орох шахмалын тоо
0.015*	1
0.03**	2
0.06	4

Жишээ нь:

*10 литр, 0,015%-ийн ажлын уусмал бэлтгэхдээ 10 литр усанд 1 шахмал жавелионыг хийнэ.

**10 литр, 0,03 %-ийн ажлын уусмал бэлтгэхдээ 10 литр усанд 2 шахмал жавелионыг хийнэ.

4. Клорсепт (Klorcept)

Үндсэн үйлчлэгч бодис: Дихлоризоцианурын хүчлийн натрийн давс

Хэрэглэх заавар:

- Эмнэлэг, айл өрх, олон нийтийн газар, сургууль, цэцэрлэгт хэрэглэж болох өргөн хэрэглээтэй. Бүх төрлийн нян ялангуяа сурьеэгийн нян, хелатит, ХДХВ, мөөгөнцөр, боомын нян устгах үйлчилгээтэй.
- Хана, шал, хаалга гэх мэт гадаргуу, шил, резин, хуванцар эдлэл, ванн, угаагуур, цагаан хэрэглэл, сав суулга, цэвэрлэгээний хэрэгсэл, лабораториуд, халдварт өвчиний голомтын халдвартгүйжүүлэлтэд хэрэглэдэг.
- Ажлын уусмал нь 2 өдөр идэвхээ хадгална. Ажлын уусмал бэлтгэхдээ паалантай сав, хуванцар эсвэл шилэн саванд бэлтгэдэг.
- Гадаргуу халдвартгүйжүүлэхдээ 1м²-д 100мл бодис орохоор бодож арчих, 300мл бодис орохоор тооцож шүршинэ.
- Сав суулгыг угаахдаа 1 иж бүрдэл сав суулгыг угаахад 4 литр уусмал, 1 кг хуурай цагаан хэрэглэлд 5 литр бодис орохоор бодож савтай уусмалд хийнэ.
- Халдвартгүйжүүлсний дараа цэвэр усаар угаанаа
- Нийтийн талбай, өрөө тасалгааны шал, хана, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг 0,02-0,03% ажлын уусмал бэлтгэж ашиглана.
- Ариун цэврийн өрөөг 0.05-0.1% ажлын уусмалаар халдвартгүйжүүлнэ.

Халдвартгүйжүүлэх уусмал бэлтгэх арга:

Бодисын нэр	Шахмалын тоо	Усны хэмжээ (л)	Идэвхтэй хлорын хэмжээ, %
Клорсепт 17 (1670мг)	1	5	0.02*
	3	10	0.03
	1	2	0.05**
	1	1	0.1

Жишээ нь:

*0,02%-ийн 5 литр ажлын уусмал бэлтгэхдээ 5 литр усанд 1 шахмал Клорсепт хийнэ.

**0,05 %-ийн 2 литр ажлын уусмал бэлтгэхдээ 2 литр усанд 1 шахмал Клорсепт хийнэ

5. Топакс 686

Үндсэн үйлчлэгч бодис: Натрийн гипохлорид, Калийн гидроксид, Диметил додецил амин оксид.

Найрлагад орсон бодис: 5% ионгүй гадаргуугийн идэвхит бодис, фосфонят, хлор цайруулагч

Хэрэглэх заавар:

- Өөх тос уургийн үлдэгдэл, органик бохирдлыг арилгах, халдвартгүйжүүлэх үйлчилгээтэй
- 2%-5%-ийн Топакс 686-аар гадаргууг хөөсрүүлж, түүнийгээ 10-20 минут хөөстэй байлгана.
- 40-60 хэмийн халуун усаар хөөсийг арилтал зайлж угаана.
- PH хяналтын туузаар гадаргуу сайн зайлгадсан эсэхийг шалгана.
- Нийтийн талбай, өрөө тасалгааны шал, хана, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг 2% ажлын уусмал бэлтгэж ашиглана.
- Ариун цэврийн өрөөг 3% ажлын уусмалаар халдвартгүйжүүлнэ.

Халдвартгүйжүүлэх уусмал бэлтгэх арга:

2 %-ийн 10 литр ажлын уусмал бэлтгэхдээ 9 л 800 мл усан дээр 200 мл Топакс 686 нэмнэ.

5 %-ийн 10 литр ажлын уусмал бэлтгэхдээ 9 л 500 мл усан дээр 500 мл Топакс 686 нэмнэ.

6. Клорклийн /Klorkleen/

Үндсэн үйлчлэгч бодис:

Натрийн трихлорсен – 30-60%
Хурганы чихний хүчил – 10-30%
Натрийн карбонат – 0-8%
Тартразин – 0-0.4%
Холимог – 10-18%

Хэрэглэх заавар:

- Клорклийн шахмал нь хөөсрөлт багатай угаалгын бодистой тусгайлан боловсруулсан, найруулж бэлтгэхэд хялбар, халдвартгүйжүүлэх, цэвэрлэх уусмал бэлтгэх зориулалттай.
- Эмнэлэг, номын сан, зочид буудал, хоол хүнс бэлтгэх газрууд, зоогийн газар, сургууль, цэцэрлэг, биеийн тамирын заал болон бусад халвараас сэргийлэх дэглэм шаардлагатай газруудад гадаргуугийн халдвартгүйжүүлэлтэд хэрэглэхэд тохиромжтой.
- Бактери, вирус, сүрьеэгийн савханцар, спор, мөөгөнцирийн эсрэг үйлчилгээтэй. Эмгэг төрөгчийг 10 минутанд 99,9% устгана
- Шахмалын хадгалах хугацаа 2 жил, ажлын уусмалын хүчинтэй хугацаа 24 цаг.
- Нийтийн талбай, өрөө тасалгааны шал, хана, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг 0,02-0,03% ажлын уусмал бэлтгэж ашиглана.
- Ариун цэврийн өрөөг 0,05% ажлын уусмалаар халдвартгүйжүүлнэ.

Халдвартгүйжүүлэх уусмал бэлтгэх арга:

Идэвхтэй хлорын хэмжээ (%)	Шахмалын тоо	Усны хэмжээ (л)
0,02*	1	5
0,03**	3	10
0,05***	1	2

Жишээ нь:

*0,02%-ийн 5 литр ажлын уусмал бэлтгэхдээ 5 литр усанд 1 шахмал Клорклийн хийнэ.

**0,03 %-ийн 10 литр ажлын уусмал бэлтгэхдээ 10 литр усанд 3 шахмал Клорклийн хийнэ.

***0,05%-ийн 2 литр ажлын уусмал бэлтгэхдээ 2 литр усанд 1 шахмал Клорклийн хийнэ.

ооОоо